

ХОВД АЙМАГ ДАХЬ ХОВД НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2019.09.24

Жаргалант сум
Бугат баг

ИНЕГ-ын даргын баталсан 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Ховд аймаг дахь Ховд нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 19/21 тоот удирдамжийн хүрээнд 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа, Ц.Цацрал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Ховд аймаг дахь Ховд нисэх буудал, Ховд аймгийн Булган сум дахь нисэх буудлын 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, нисэх буудлын даргын гаргасан тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, хүний нөөц бүрдүүлэлт, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, анхан шатны баримт бүрдүүлэлт, худалдан авалт, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Ховд аймаг дахь Ховд нисэх буудлын 2018 оны үйл ажиллагааны үр дүнд аудитын шалгалтыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн ба 2018 оны санхүүгийн аудитын шалгалтаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

Холбооны инженер Н.Отгонбаяраар ахлуулсан орон тооны бус дотоод хяналтыг ажиллуулж байгаа нь үр дүнгээ өгсөн байна. Дотоод хяналтыг зөвхөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хийж байгааг цаашид өргөжүүлж захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд ч дотоод хяналтыг хийж байх, захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд хэрхэн дотоод хяналт хийх, юунд анхаарах талаар зөвлөгөө өглөө.

Ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлэлт дутуу баяжилт муу, хөдөлмөрийн гэрээний нэмэлт өөрчлөлтүүд хийгдээгүй байна.

Албан тушаалын тодорхойлолтын шаардлага хангасан ажилтныг сонгон шалгаруулж авахгүй байна.

Архивын баримтын хадгалалт хамгаалалт, үдэлт цэгцлэлт хангалтгүй, архив бичиг хэргийн хөтлөлтийн заавар, стандартыг мөрдөж ажиллаагүй.

Дизель генераторын болон автомашины тээврийн хэрэгслийн хувийн хэрэг хөтлөлт хангалтгүй дутуу хийгдсэнээс шаардлагатай сэлбэг хэрэгслийн нормыг хянах боломжгүй байна.

Анхан шатны баримтгүйгээр 11 гүйлгээ хийсэн байна.

Зардлын төрлийг буруу сонгосноос зардлын зүйл анги сольж гүйлгээ хийжээ.

Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад мөнгөн тооцоогоор зөрчил илэрсэн.



Хоолны үнийн хөнгөлөлтийн тооцоогоор цалинтай чөлөө авсан 20 ажилтанд хоолны үнийн хөнгөлөлт илүү олгосон.

Албан байгууллагуудтай хийгдсэн гэрээнд гарын үсэг зураагүй, гэрээг дугаарлаагүй, гэрээг дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээний бүрдэл хангалгүй зөрчил нийтлэг байна.

Худалдан авах болон ажил үйлчилгээ үзүүлэхдээ хуулийн дагуу зохион байгуулах, гэрээг хуулийн хүрээнд боловсруулах, гэрээг дүгнэж акт бүрдүүлж байх шаардлагатай байна.

Нислэгийн өмнөх, дараах шүүмж яриаг тогтмол хийж тухайн өдрийн нислэгийн үйл ажиллагаанд гарсан алдаа, зөрчил, дутагдлыг хэлэлцэж, гарсан алдаа зөрчлийг тухай бүр залруулж ажиллажээ.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хангаж ажиллахад анхаарч, хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх шаардлагатай.

Булган сум нисэх буудлын аэродромын түр зөвшөөрлийн хүчинтэй хугацаа 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр дуусгавар болж байгаа бөгөөд ИНД-139.13(b) заасны дагуу гэрчилгээ сунгуулах хүсэлтийг гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлсэн байх ёстой байтал 20 хоног хугацаа хэтрүүлж хүсэлтээ хүргүүлсэн байна.

Булган сум нисэх буудлын бичиг хэрэг хариуцсан ажилтан архивын хадгаламжийн нэгжийг боть болгон үдэж цэгцлээгүй, архив, албан хэрэг хөтлөлтийн зааврыг мөрдөж ажиллаагүй байна.

Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, засаж залруулах талаар 10 зөвлөмж хүргүүлсэн.

ДОТООД АУДИТЫН АЛБА